

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
08 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 9 өргөдөл бичгээр хүлээн авч, 7 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2, аймгийн Засаг даргын Тамгын газарт 2 өргөдөл тус тус хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажиллав.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 37 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 27, биечлэн 10 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 22, санал хүсэлт 11, шүүмжлэл 4 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 29 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэж шийдвэрлэлт 78.4 хувьтай байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 12 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 8 санал хүсэлтийн хариуг илгээж, 4 санал хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 78 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан төслийг аймгийн хэмжээнд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон, ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу орон нутгийн иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах, чиглүүлэгчдийг бэлтгэх бүсчилсэн нэгдсэн сургалтыг 2017 оны 08 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Мөст, Жаргалант, Эрдэнэбүрэн сумдад зохион байгуулсан.

2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санал асуулга, хэлэлцүүлэгт 15 сумын 5220 иргэнийг хамруулж, 3979 саналын хуудас бөглүүлж авсан ба мэдээг Улсын Их Хурлын Тамгын газарт тухай бүр тайлагнаж байсан. Аймгийн хэмжээнд санал авах ажиллагаа 76,23%-тай байгаа болно.

**Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын 8 дугаар сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хянаж хугацаанд нь санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл 8 дугаар сарын байдлаар төсвийн орлогод 4452.4 сая төгрөг орж төлөвлөгөө 264.5 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар тасарсан байна. Үүнээс татварын орлогод 4002,1 сая төгрөг орж төлөвлөгөө 243.7 сая төгрөгөөр буюу 5,7 хувь, татварын бус орлогод 418,2 сая төгрөг оруулж төлөвлөгөө 0,4 сая төгрөгөөр буюу 0,1 хувиар тус тус тасарсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 122.0 сая, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1420.1 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 251.4 сая, нийт 1793.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс орон нутгийн хөрөнгө хөрөнгө оруулалт 106.4 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 128.3 сая, ОНХС-аас 1273.1 сая, нийт 1507.8 сая төгрөг олгосон нь төсөвлөснөөс санхүүжилт 285.7 сая төгрөгөөр дутуу байна.

Сумын ИТХ-аар хэлэлцүүлэн төсвөө тодотгон баталсан 14 сумын төсөв, сарын хуваарийг байгууллага, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар төсвийн Фискал программд шивж Сангийн яаманд бааз мэдээллийг хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн 2018 оны төсөл, 2019-2020 оны дунд хугацааны төсөөллийг хуваарийн дагуу сум, байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ИТХ-ын Төлөөлөгчдөд танилцуулж, тэдний санал хүсэлтийг тусган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулж Сангийн яаманд хүргүүлсэн ба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2018 оны төсөл, 2019-2020 оны төсөөллийг салбар тус бүрээр гаргаж, харьяалагдах яамдуудад танилцууллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр эрх нь шилжиж ирсэн санхүүжилтийн ажлын гүйцэтгэл, баримтын бүрдлийг шалгаж ЭМС-ын эрх шилжсэн 1182.8 сая төгрөг, БСШУС-ын 370.3 сая төгрөгийг мөн ОНХС-аас аймаг, сумдын мал эмнэлэг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 46.2 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу тус тус олгоод байна.

Төрийн сангийн төлбөр тооцооны Freebalance программаар нийт 37 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 6,4 тэрбум төгрөгийн 809 ширхэг гүйлгээ хийгдээд байна.

Татварын хэлтэс нь 252 татвар төлөгчдөд лавлагаа тодорхойлолт гаргаснаас виз хүссэн 28, зээл авах 102, эрх шилжүүлэх 5, зөвшөөрөл сунгах 2, тендерт оролцох 53, бусад 57 лавлагаа тодорхойлолт гаргав.

Хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулах, бүхий л эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 34 хамаарагчтай 9 агуулагчтай татвар төлөгчийн 85 ширхэг 1924.5 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулав.

Статистикийн хэлтсээс “Өрхийн нийгэм эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны түвшин болон боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлтийн байдлыг тогтоох судалгааг Жаргалант сумын Бичигт, Зэрэг сумын Хөндлөн, Мөст сумын Улаан толгой багуудын нийт 26 өрхөд түүврийн аргаар тусгай таблетаар авч, нэгтгэн Үндэсний Статистикийн хороонд хүргүүлээ.

Графикт шуурхай 10 гаруй төрлийн мэдээг хугацаанд нь авч, бүрэн дамжуулав. Аймгийн хэмжээний тариалсан талбайн мэдээг 870 орчим өрх, 17 гаруй аж ахуй нэгжээс авч нэгтгэн шивж дуусгаад байна.

**Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:** 2018 оны хөрөнгө оруулалтын төсөв, 2018-2020 оны төсвийн төсөөлөлд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтанд салбарын хүрээнд тусгуулах хөтөлбөр, арга хэмжээний талаар хууль сахиулах байгууллагын удирдлагуудын уулзалтыг зохион байгуулж санал солилцон уулзалтаас гарсан саналыг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв

Хэлтсийн хурал 3 удаа хуралдаж, 9 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 3 иргэний анхан шатны баримт бичиг боловсруулж хууль эрх зүйн туслалцаа үзүүлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээнд ард нийтийн оролцоог нэмэгдүүлж бүрэн хамруулахад санаачлагатай ажиллаж тус хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагууд, ард түмний төлөөллийг оролцуулж санал авах ажлыг амжилттай зохион байгууллаа.

Архивын тасаг нь тайлант сард нийт 20 иргэнд лавлагаа магадлагаа олгож, 72, 75 дугаар хөмрөгийн 1984-2004 оны 16 хадгаламжийн нэгж буюу 1484 хуудсыг цахим мэдээллийн санд оруулав.

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд 2017 оны 08 дугаар сарын 25-ний байдлаар 27 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл хулгайлах 9, үүнээс иргэдийн өмчийн хулгай 8, хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 1, бусдыг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 2, хөрөнгө завших

2, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2, хүчиндэх 1 гэмт хэргүүд бүртгэгдсэн.

Аймагт гарч буй гэмт хэргүүдээс хулгай үүн дотроос орон байрны хулгайн гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж байгаад дүгнэлт хийж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, аймгийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, судалгаа шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах, холбогдох удирдлагуудад асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх зорилгоор Цагдаагийн газрын дэргэд орон тооны бус ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Орон байрны хулгайн болон дээрмийн гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сар, улирлын статистик судалгаа мэдээнд тулгуурлан эргүүлийн үүрэг гүйцэтгэх цагийг тодорхойлж, гэмт хэрэг илрүүлэх албадын үйл ажиллагааг сайжруулах сэжигтэй газар орон байр, барилга байгууламж, нутаг дэвсгэрт тодорхой төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, шөнө оройн цагаар үйлдэгддэг гэмт хэрэг зөрчлийн шалтгааныг тогтоох, түүний гаралтыг бууруулах зорилгоор НХЖХТ-ийн эргүүлийн алба хаагчид 09-19 цаг хүртэл өдрийн эргүүл, 19-02 цаг хүртэл оройн эргүүл хийж тодорхой үр дүнд хүрч байна.

Архины хамааралтай 20, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн баривчлагдсан 2 иргэнд аймгийн “Архичид амигчлахуй” төрийн бус байгууллагатай хамтран архины хор хөнөөлийн талаар сургалт зохион байгуулж, бүртгэл судалгаа хийн хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн газар нь тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 191 гомдол мэдээлэл хүлээн авсны 29 буюу 15.0 хувийг гэмт хэргийн, 162 буюу 85.0 хувийг захиргааны зөрчлийн гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд зөрчил гаргасан 32 хүнийг албадан саатуулж, 22 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 419 хүнийг 30.127.500 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

**Ховд аймаг дахь шийдвэр гүйцэтгэх алба-Хорих 457 дугаар анги:** Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагт алба хаагчдыг бүртгэн, ажлын цаг ашиглалтанд

байнгын хяналт тавьж 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна

Тус албаны Цагдан хорих байр болон конторын шинээр баригдах барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 13 хоригдолыг барилгын туслах ажилтнаар ажиллуулах гэрээ байгуулан ажиллуулж байгаа ба барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна.

2017-2018 оны өвөлжитийн бэлтгэл ажил хангуулах, хадлан тэжээл бэлтгэх, ногоо хураалтын ажилд нэр бүхий 10 хоригдолыг аймгийн Прокурорын газрын зөвшөөрлөөр харуул хамгаалалтын хяналтан дор ажиллуулж хадлан бэлтгэх ажлын явц 80, ногоо хураалтын ажлын явц 70 хувьтай байна.

Хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албаны даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин ажиллаж байгаа ба ангийн өдөр тутмын үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд хэвийн явагдаж хоригдол, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс нь тайлант сард нийт 8 өргөдөл, гомдол хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн төдийгүй 2763 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 2026, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 413, шилжин ирсэн иргэд 69, шилжин явсан иргэд 46, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 298, Гадаад паспорт олголт болон сунгалт 337, Иргэний үнэмлэхийг 160 иргэнд шинээр олгож сунгалт 251, дахин олголтыг 172 иргэнд олгож тус тусын үйлчилгээг үзүүлэв.

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлээр 259 иргэнд үйлчилсэн ба үүнээс: Төрөлт 170 иргэн, үрчлэлт 2, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 6 иргэн, эцэг тогтоолт 7, гэрлэлт 43, гэрлэлт цуцалсны бүртгэлийг 3 иргэнд, нас барсны бүртгэл 30, нөхөн бүртгэл 5, иргэний бүртгэлийн лавлагаа олголтыг 427 иргэнд олгож,

мөн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 678, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 59 иргэнд тус тусын холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав.

**Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** 2017-2018 оны хичээлийн жилийн багш нарын бага хурлыг 08 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, хуралд Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нарын төлөөлөл нийт 260 хүн хамрагдаж, хичээлийн жилийн бэлтгэл хангах ажлын хүрээнд:

1.Хичээлийн жилийн зорилго, зорилтыг тодорхойлж 2017-2018 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт

2. Сургууль, цэцэрлэгийн ажилд хяналт үнэлгээ хийх журам

3. Багшийн ажлыг үнэлэх журам, кабинетийн гэрчилгээ олгох, багшид мэргэжлийн зэрэг олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлуудыг хэлэлцэж баталлаа.

Жаргалант сумын сургуулийн өмнөх боловсролын багш нарт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролд тэгш хамруулах нь” сэдэвт сургалт зохион байгуулж, тус сургалтанд сургуулийн өмнөх боловсролын 30 багш хамрагдав. Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд багшаар ажиллах эрх олгох шалгалтыг 2017 оны 08 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж, 259 иргэн бүртгүүлж, 259 оролцогч шалгалтад оролцосноос 120 оролцогч тэнцэж 139 шалгуулагч тэнцээгүй болно.

БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Швейцарийн хөгжлийн агентлагаас хамтран “Багшийн ёс зүй-ёс суртахууны харилцаа” -ны модулийг боловсруулан гаргасан бөгөөд лаборатори ахлах 1 дүгээр дунд сургуулийн 12 багш, Боловсрол, соёл, урлагийн газрын 10 мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэж, аймгийн хэмжээний 24 сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, багш нарын төлөөлөл, цэцэрлэгийн эрхлэгч нийт 375 хүнд Багшийн ёс зүй ёс суртахууны харилцаа, Бүрэн дунд боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сэдэвт сургалтыг 08 дугаар сарын 24-27-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

2018 оны төсвийн төслийг харьяа 88 нэгж байгууллагаас хуваарийн дагуу хүлээн авч нэгтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлэв.

ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлгээр манай аймгаас Тувагийн их сургуульд суралцах эрх авсан 18 суралцагчийн баримтыг бүрдүүлж, визийг нь гаргах болон суралцах бэлтгэлийг нь хангаж ажиллаа.

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллах шаардлагатай багшийн судалгааг нэгж байгууллагаас авч ард иргэдэд нээлттэй мэдээлэв.

БСШУЯ-ны зөвшөөрлөөр хэвлэлийн 7 компани 6-12 дугаар ангийн нийт 57 төрлийн, 1-5 дугаар ангийн 33 төрлийн сурах бичиг нийлүүлснийг хүлээн авч сургуулийн захиргаа болон номын санд хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Баруун бүсийн Цагдаагийн хүрээний аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 08 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, тэмцээнд Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймгуудын цагдаагийн газар, хэлтсүүдийн 120 гаруй баг тамирчид оролцов.

“Эртэч Ховд” аяны хүрээнд өглөөний гүйлт, гимнастик, хийн дасгал, спорт заалны чөлөөт тоглолтын үйл ажиллагаа хуваарийн дагуу хэвийн явагдаж байна.

Биеийн тамир, спортын газрын түүхт 70-н жилийн ойн баярыг угтсан ажлын төлөвлөгөө гарган эрчимтэй ажиллаж байгаа бөгөөд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн дотор, гадна засвар, спортын том, жижиг заал, албан өрөө, бэлтгэлийн танхим, алдрын булан, самбар болон гадна засвар, тохижилтын ажлууд хийгдэж байна.

**Соёлын чиглэлээр:** НКВ international holding ХХК-ны баруун бүсийн босоо тэнхлэгийн дагуу зам барьж байгаа ПК68+060 дахь км буюу N48 13.107:E91 32.480 солбицолд орших Ховд сумын Хавцгайтын Дэрстийн хөтлийн хадны зургийг авран хамгаалах, зөөн тээвэрлэх, хүрээлэнд байрлуулах ажлыг Соёлын өвийн төвийн мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэж байна.

Аймгийн Музей нь тайлант сард аялагчид болон нутгийн ард иргэдийг түүх, соёлын дурсгалуудтай танилцуулан 1,000,000 /нэг сая/ гаруй төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлсэн байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрүүл мэндийн яамнаас 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь 21 аймагт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг сайжруулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж байгаатай холбогдуулан манай аймагт 2017 оны 08 сарын 04-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн

үндэсний төвийн захирал Б.Цогтбаатараар ахлуулсан баг 1 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулж, орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлуудтай газар дээр нь танилцаж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж, гэрчилгээ олгов.

Түүнчлэн “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн долоо хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн онцлогт тохируулан аян зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан БОЭТ, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, эхийн сүүний ашиг тус, эхийн сүүгээр хооллолтыг дэмжих шторк, санамж зөвлөмжийг орон нутгийн Ховд телевиз, Эрүүл мэндийн газрын Facebook хаяг, аймгийн нэгдсэн зарын сайтуудад байршуулан мэдээллийг ард иргэдэд тухай бүр хүргэж эхийн сүүгээр хооллолтыг дэмжих арга хэмжээг авч ажиллав.

“Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн долоо хоног”-ийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэнгээс 2017 оны 08 сарын 01-нд зохион байгуулсан цахим сургалтанд өрхийн эрүүл мэндийн төвийн эмч болон БОЭТ-ийн эмэгтэйчүүдийн эмч мэргэжилтнүүдийг хамрууллаа. Мөн сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд жирэмсэн, хөхүүл эхчүүд болон албан байгууллагуудын удирдлагуудад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж нийт 600 орчим хүнийг хамруулж эхийн сүүгээр хооллолтын ач холбогдлын талаар мэдлэг олгож, хүнсний тухай хуулийг сурталчилан эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө өгч ажиллав.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр цайр 65 хайрцаг, хорсол 30 хайрцаг тус тус ирсэн бөгөөд өрх, сумын эрүүл мэндийн төв, БОЭТ-ийн хүүхдийн тасагт олгоод байна. “Өсвөр үе-Ирээдүйн босго төв”-өөр 11 хүүхэд үйлчлүүлж, 7 хүүхдийг үзлэг шинжилгээнд хамруулав.

Тарваган тахал өвчний дархлаажуулалтад голомтот нутгийн 13 сумын 60 насны 2507 иргэнийг хамрууллаа. Томуу, томуу төст өвчний тандалтын мэдээг <http://fis.flu.mn/> цахим хаягт оруулж, 8 дугаар сарын 23-ны байдлаар томуугийн тандалтаар томуу, томуу төст өвчний үзлэгийг 262 иргэнд үзүүлэв. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа хепатит С, В вирусын илрүүлэг шинжилгээнд 40-65 насны 8561 хүн хамрагдаж, хамралт 44,9 хувьтай, В, С вирус 91 хүнд илэрсэн байна. Хамралт Цэцэг сум 90,8 хувь, Мянгад сум 82,9 хувь, Алтай сум

73,4 хувь, Булган сум 28,7 хувь, аймгийн төв /БОЭТ/ 25,7 хувь, Ховд сум 30,7 хувьтай байна.

"Улаанбурхан өвчний бэлэн байдал, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний аргачлал, халдварт саа өвчин гарахаас сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг боловсруулах" баруун бүсийн сургалтыг 2017 оны 08 дугаар сарын 21-ны өдөр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албатай хамтран зохион байгууллаа.

Эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдол бүртгэгдснийг холбогдох журмын дагуу хэлэлцэж, дүнг дээд шатны байгууллагуудад хүргүүлээ.

Хүүхэд, нярайн эндэгдлийн 16 тохиолдол гарсан ба эмнэлэгийн магадлан хянах комиссоор хэлэлцэж дүгнэлт гарган цаашид хүүхдийн эндэгдэл гаргахгүй байх ялангуяа урьдчилан сэргийлж болох эндэгдэл гаргаж байгаад анхаарч ажиллах, тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг хэлэлцлээ.

2017 оны 7 дугаар сард 1276 эх амаржиж, 1289 хүүхэд мэндэлсэн ба шинээр төрсөн хүүхдийн 4,7 хувийг 2500 гр-аас доош жинтэй хүүхэд эзэлж байна. Жирэмсэн эхийн эхний 3 сартайн хяналт 89,3 хувь эзлээд байна.

2017 оны 7 сарын байдлаар нас баралт 239 бүртгэгдсэнээс 58,9 хувь нь эмэгтэй, 41,1 хувь нь эрэгтэй, 0-1 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 27 буюу 1000 амьд төрөлтөнд 20,9 хувь ноогдож байгаа дүн мэдээ гарсан.

Бүсийн оношлогоо эмчилгээний төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд 3 дугаар улиралд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх тендерийн сонгон шалгаруулалтыг зарлаж, 10,072,465 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслэлийг 16 сумын ЭМТ-д түгээлтээр хүлээлгэн өгөв.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд анхаарч 11 төрлийн халамжийн үйлчилгээнд 33197 иргэнийг хамруулж 5,5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн сангийн судалгааны дагуу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур иргэдийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 3 өрхөд амьжиргааны түвшний тодорхойлолт гаргаж тус өрхийн 18-с дээш насны өрхийн гишүүн иргэдийг эрүүл мэндийн даатгалд үнэ төлбөргүй хамрууллаа. Шинээр

мэндэлсэн 53 хүүхдийг өрхийн мэдээллийн санд нэмж бүртгэв.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль” болон Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол, 2013 оны 20, 144, 311 дүгээр тогтоолууд, 2016 оны 94 дүгээр тус тус тогтоолын дагуу 2017 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай гэрээ байгуулж, гэрээний дагуу орон нутгийн “Нэвт” амралт, сувилалд 176 ахмад, “Эвт урлал” амралт сувилалд 20 ахмад амарч сувилуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймгийн салбар комисс 2017 оны 08 дугаар сарын 09, 23-ны өдрүүдэд хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 32 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрууллаа.

Ортопедийн тусгай хэрэгсэл авах хэрэгцээ, шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс өмнө нь уг үйлчилгээнд хамрагдаж байсан эсэхийг халамжийн сангийн программд нэрээр нь тулган шалгаж үйлчилгээ авах эрх үүссэн 12 иргэнд ортопедийн туслах хэрэгсэлийг олгож waic программд бүртгэв.

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:** Тайлант сард нийт 25 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 674 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 1730 байх ба үүнээс эмэгтэй 923 байна. Ажил идэвхитэй хайгчдаас 780 иргэнийг ажлын байранд зуучилж, шинээр бий болсон 402 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS санд орууллаа.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллага иргэдээс 852 ажлын байрны захиалга авч бүртгэлтэй ажил хайгч иргэд 780 байгаа ба үүнээс эмэгтэй 368 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Байнгын 442, улирлын 127, түр 211 ажлын байртай болсон байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөнд 69 иргэнийг хамруулсан ба хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд “Ховдын өргөө” ХХК-тай хамтран бетон арматурчин мэргэжлээр 12 иргэнд үйлдвэр дээрх сургалтыг зохион байгуулж 12 иргэнийг байнгын ажлын байранд зуучлав.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд эхний 8 сарын байдлаар 95 иргэнд 176,0 сая төгрөгийн хүүгүй зээлийг олгож, хувиараа хөдөлмөр эрхлэгч 95 иргэн үйл ажиллагаагаа өргөжүүлж ажлын байртай

болсон байна.

ХЭДС-ийн жижиг зээл олгох арга хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч жижиг дунд өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 59 аж ахуйн нэгжид 643,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 94 шинэ ажлын байр, түр болон улирлын чанартай 12, хадгалагдсан ажлын байр 85 байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд МБСБ төгссөн 18 төгсөгчдөд 36,0 сая төгрөгийн хүүгүй зээл олгож, тоног төхөөрөмж, материал авахад дэмжлэг үзүүлсэн ба байнгын ажлын байртай болсон.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 19 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж 62,5 сая төгрөгийн санхүүжилт зарцуулж 154 түр ажлын байрыг бий болгоод байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 150 ахмад мэргэжилтэн хамрагдаж өөрсдийн арвин туршлагаа хойч үедээ өвлүүлж үлдээх чиглэлээр зөвлөгөө өгч ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 42 иргэнд 60,0 сая төгрөгийн хүүгүй зээл олгож хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүллээ.

Асруулагчдад стандартын дагуу өдөрт 4 удаа, 7 хоногт 15 нэр төрлийн хоол хүнсээр үйлчилж, асруулагчдыг халуун усанд оруулж, хэвтрийн асруулагчдад өдөр бүр тогтмол мэргэжлийн асаргаа үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Нийгмийн даатгалын системийн хэмжээнд 2017 оныг “Эерэг хандлага-Чанартай үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулан, шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд биелүүлж, иргэд даатгуулагч, өндөр настан, ажил олгогчдод үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг хөнгөн шуурхай хүртээмжтэй хүргэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж сангийн орлогыг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж, тайлант сард сайн дурын 5322 даатгуулагчийн 774,0 сая төгрөг, 9538 даатгуулагчийн 414,1 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын орлого төвлөрүүлж, 739 ажил олгогч 13203 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 8,156 сая төгрөг төвлөрүүлэх тооцоотой байна. Өндөр насны тэтгэвэрт 7621 хүнд 3843156.1 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1798 хүнд 416442.7 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 892 хүнд 215132.3 мянган

төгрөг, цэргийн тэтгэвэрт 206 хүнд 37226.4 мянган төгрөг, үйлдвэрийн ослын тэтгэвэрт 23 хүнд 84866,5 мянган төгрөгийг тус тус зарцуулав.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 818 даатгуулагчид 741369.8 сая төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 504 даатгуулагчид 46366.3 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 206 даатгуулагчид 270282.8 сая төгрөг, 193 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 206,000,000 төгрөгийг тус тус олголоо.

ЭХМКомиссын ээлжит хурлыг 08 дугаар сард 2 удаа зохион байгуулж нийт 75 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны асуудлыг хэлэлцэж 41 иргэний актыг сунгаж, 8 иргэний актыг цуцалсан ба 26 иргэний хугацааны актыг шинээр тогтоов. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3227 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** “Гэр бүлийн маргааныг шийдвэрлэх болон гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхжуулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж байгаа судалгааг гаргаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн ба хүүхдийн эрх зөрчигдсөн асуудлаар 4 кейст нөхцөл байдлын үнэлгээ хийж, тохирох үйлчилгээг үзүүлэв.

Ази Номхон далайн бүсийн 31 дүгээр Жембори 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба аймгаас 70 хүүхэд, 8 хариуцагч багш нар амжилттай оролцлоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн төвөөс санаачлан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран “Залуучууд ба Тогтвортой хөгжил” чуулганыг зохион байгуулж, тус арга хэмжээнд Жаргалант сумын 12 баг тус бүрээс залуучуудын 3 төлөөлөл, 16 сум тус бүрээс 5 төлөөлөл, залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх клуб, зөвлөлийн гишүүд нийт 150 гаруй залуучууд хамрагдав.

Чуулганд оролцогчид орон нутгийн болон үндэсний бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэнд залуучуудын оролцоог хангах, төр засгийн шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэх, нөлөөлөх зорилготой ИТХ-ын дэргэдэх залуучуудын зөвлөлийг байгуулж, залуучуудыг идэвхижүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөр хоорондоо танилцах хамтач оролцоог нэмэгдүүлэх,

харилцан туршлага солилцох зорилгоор спорт, урлагийн арга хэмжээг зохион байгуулав.

**Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:**

**Байгаль орчны чиглэлээр:** Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн Үндэсний байгууллагатай хамтран "Экологийн бүс нутгийн үр дүн, газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудал", Уур амьсгалын ногоон санд "Баруун бүсийн тогтвортой хөгжил"-ийн асуудлаар хөрөнгө оруулалтын төсөл бэлтгэн уламжлах баруун бүсийн зөвлөлдөх уулзалт, нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймгуудын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Усны сав газрууд болон МОН/16/301 төслийн төлөөлөл, Монгол Оросын Холбооны улсын эрдэмтэн судлаачид оролцов.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, Хар-Нуур Ховд голын сав газартай хамтран сумын хэмжээний инженерийн хийцтэй болон энгийн гар худгуудын тооллогыг амжилттай зохион байгуулж 463 худгийг тооллогод хамруулж бүртгэлжүүлэв. Үүнээс 96 инженерийн хийцтэй худаг, 367 энгийн гар худгууд байна. Тооллогын явцад зөвшөөрөлгүй, паспортгүй худгуудын судалгааг давхар гаргаж зөрчлийг арилгуулхаар ажлын хэсэг ажиллаж байна.

Усны тухай хуулийн 27.1 дэх заалтыг үндэслэн "Булган хөрс" ХХК-ний худаг гаргаж ашиглах зөвшөөрөл, мөн компанийн шатахуун түгээх станцын унд ахуйд ашиглах худагны зөвшөөрөл, "Хар Нүх" ХХК-ний кемпийн ажилчдын унд ахуйд ашиглах худагны зөвшөөрлийг тус тус олгов.

Жаргалант сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 16 авто угаалгын газруудаар хяналт шалгалт хийж усны үнэ цэнэ, зүй зохистой хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, тус газруудад усны тухай хуулийн 28.4, 28.6 дахь заалтын дагуу дүгнэлт гаргуулж байх үүний үндсэн дээр зөвшөөрөл авч хуулийн хүрээнд хамтран ажиллах шаардлага тавьж, ажиллав.

Үенч сумын Хилийн цэргийн анги албан хаагчдын орон сууц барих зориулалтаар барилгын шар шавар авах зөвшөөрөл хүссэний дагуу шавар авах цэгээс 25 машин буюу 150м<sup>3</sup> шавар олгож, орон нутгийн төсөвт 225,0 мянган төгрөгийг, мөн сумын Улаан үзүүрийн урд дэнжид Гаалийн хяналтын талбай орчмын

газарт барилга, зам барих ажилд хайрга авах гэрээг Мо-Эн-Ко ХХК-тай хийж түгээмэл тархацтай байгалийн нөөц ашиглалтын төлбөрт 30 сая төгрөг, тус талбайд “Алтайн зам” ХХК 500:250 нүүрсний тоосжилт бууруулах хашааны шонгийн хөл цутгах ажилд 450м<sup>3</sup> хайрга авах гэрээ хийж 900,0 төгрөг орууллаа.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Зооноз өвчин судлалын төв, Хар-Ус нуур орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагуудын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрт иргэдийн хууль бусаар ан амьтан агнах барих, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах, тээвэрлэх, хөдөө орон нутагт тарваган тахал өвчин шинээр сэргэж буй байгалийн голомтот халдварт өвчнөөс сэргийлж, амьтдын гаралтай мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэлтэнд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай”, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах шалгалтыг эрчимжүүлж 2017 оны 08 дугаар сарын 18-19-ны өдрүүдэд Ховд-Улаанбаатар чиглэлийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэдийн ачааг шалгаж тарваган тахал өвчний талаар сэрэмжлүүлэг материал тараан орон нутгийн Ховд телевизээр мэдээлэл хийж анхааруулга өгч ажиллав.

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Аймгийн 16 сумын хэмжээнд бэлчээрийн ургацыг фотомониторингийн аргаар тогтоох ажлыг “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран зохион байгуулж дүнг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн нэгжийн захиргаанд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/260 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын баталсан удирдамжаар “Зарим сумдын хээлтүүлэгч малд бруцеллёз, адуунд ям, үхэрт сүрье, өвчнийг илрүүлэх харшил сорилын шинжилгээ хийх” ажлын хэсэг Алтай, Үенч, Булган, Мөст, Цэцэг, Дарви, Зэрэг, Мөнххайрхан, Манхан сумдад ажиллав. Энэ үйл ажиллагаанд сумдын Мал эмнэлэг үржлийн тасгийн болон багийн Мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч нар хамтран ажилласан ба шинжилгээг сум, баг тус бүрээр нь тухайн сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн лабораторид Роз-бенгалын урвал

MNS:5198:2002 стандарт аргаар хийж гүйцэтгэсэн ба шинжилгээний дүнг нэгтгэж, урвалаар эерэг гарсан болон сэжигтэй дээжийн ийлдсийг ялган авч баталгаажуулах шинжилгээ хийхээр тусгайлан авав.

Нийт 9 сумын 45 багийн 31 Мал эмнэлэг үржлийн нэгжийн харъяалалд хамрагдах 6189 толгой малыг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн ба үүнээс Булган сумын 6 багийн 415 цусны дээж, Үенч сумын 5 багийн 307, Зэрэг сумын 5 багийн 580, Мөст сумын 5 багийн 690, Алтай сумын 4 багийн 409, Мөнххайрхан сумын 4 багийн 616, Манхан сумын 6 багийн 826, Цэцэг сум 4 багийн 601, Дарви сумын 543 ширхэг нийт 4985 цусны дээжинд тус тус шинжилгээ хийснээс шинжилгээний явцад Манхан сумын Зэрэг гол багийн малчин Лувсанжамцийн хотноос 10 ишиг, 9 хурганы цусны ийлдэс, Мөнхжавын хотноос 5 ботгоны цусны ийлдэс, Дашпүрэвийн хотноос 5 ботгоны цусны ийлдэс, Таванзуугийн хотноос 5 ботгоны цусны ийлдэс, мөн Ботгон багийн малчин Ц.Ганхуягийн хотноос 5 ишиг, 5 хурганы цусны ийлдэсийг онош тодруулах шинжилгээнд хамруулахаар Улсын ариун цэврийн төв лабораторит хүргүүлээд байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Лабораторийн ариун цэврийн тасаг нь 2320 кг махнаас 258 дээж, 100 ширхэг өндөгнөөс 10 дээж, 2910 кг сүүнээс 63 дээж авч ариун цэврийн шинжилгээ хийж, 1030 кг ноосонд гарал үүслийн гэрчилгээ олгож, Улсын нөөц, Хан орд, Цагаан морь захуудад 2650м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийв.

Засгийн газрын 186 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 05 тоот албан даалгаврын хүрээнд аймаг 60000 тн хадлан, 4000 тн гар тэжээл, 5775 тн хужир шүү бэлтгэхээс 08 дугаар сарын 24-ны байдлаар хадлан 29323 тн, гар тэжээл 244 тн, хужир шүү 2543,2 тн-ыг тус тус бэлтгээд байна. Энэ нь нийт бэлтгэх хадлангийн 48,8%, гар тэжээлийн 6,1%, хужир шүүний 44,0%-ийг тус тус эзэлж байна.

2017 оны ургацын урьдчилсан балансаар үр тариа 222,4 га-аас 216,4 тн, төмс 671,5 га-гаас 9905,5 тн, хүнсний ногоо 806,6 га-гаас 12147,4 тн, малын тэжээл 440,1 га-гаас 2162 тн, нийт 2140,5 га-гаас 24431,3 тн ургац хураахаар төлөвлөсөн ба 08 дугаар сарын 24-ний өдрийн ургац хураалтын явцын мэдээгээр төмс 70,9 га-гаас 1107,6 тн, хүнсний ногоо 297,1 га-гаас 2826,3 тн, нийт 368 га-гаас 3933,7 тн ургац хураан аваад байна.

2017 оны 9 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдах “Chinggis Khan cup-2017” олон улсын хоолны фестивалийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол үндэсний

болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх, салбарын ажилчдын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” уриан дор баруун бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах уралдаан тэмцээн, сургалт, спорт, урлагийн наадмыг аймагтаа 2017 оны 8 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд аймгийн удирдлагууд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, үйлчилгээний гавъяат ажилтан, Монгол улсын мастер тогооч, Монголын мастер тогоочдын холбооны ерөнхийлөгч болон Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий, Увс аймгуудын баг нийт 220 гаруй оролцогчид хамрагдав.

Тус наадмын үеэр Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, тогооч, зөөгч нарын дунд сургалт, семинар, спорт, урлаг, ур чадварын уралдаан тэмцээнүүд амжилттай зохион байгуулагдлаа.

**Авто замын чиглэлээр:** Зам тээврийн хөгжлийн яамнаас үүрэг чиглэл өгсөний дагуу зам засвар арчлалтын “Ховд АЗЗА” Төрийн өмчит хувьцаат компани нь улсын болон олон улсын чанартай авто зам дагуух гээгдсэн, эвдэрсэн тэмдэг тэмдэглэгээг нөхөн сэргээж, суулгах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: А1701 дугаартай Ховд-Улаангом чиглэл, А31 дугаартай Ховд-Улиастай чиглэл, А14 Ховд-Булган-Улсын хил чиглэл, А0304 Ховд-Алтай чиглэл, Булган-64 км-т 5 чиглэлийн хатуу хучилттай авто замд нийт 280 босоо тэмдгээр тэмдэгжүүлэхээс гадна Ховд-Булган-Улсын хил чиглэлийн зам дагуу амьдардаг айлуудаар Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэргийг сурталчлан ухуулах арга хэмжээг аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулав.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд 3 км явган замыг “Зол дайчин” ХХК, Жаргалант суманд 10 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, Ховд-Чандмань чиглэлийн авто замын ТЭЗҮ боловсруулах ажлыг “Гео зураглал” ХХК тус тус гүйцэтгэж байна.

**Барилга хот байгуулалтын чиглэлээр:** Жаргалант сумын Засаг даргын санал, газар өмчлөх иргэдийн хүсэлтийг хүлээн авч хянан 15 иргэний газар өмчлөлийг баталгаажуулан улсын бүртгэлд бүртгүүлэв. Мөн газрын хэмжээ талбай

хаягийн зөрчилтэй 6 иргэний зөрчлийг арилгаж, гэр бүлийн хэрэгцээнд хамтран газар өмчилсөн 1 өрхийн 3 иргэний газар өмчлөх эрхийг нээсэн ба газрын хэмжээ талбай өөрчлөх 2 иргэний хүсэлтийг хүлээн авч гэрээ байгуулан, аймгийн Засаг даргын захирамж гарган гэрчилгээ олгов. Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулсан 2 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан эрхийг нь шилжүүлж 34 иргэний газрын кадастрын зураг гаргав.

Концессын гэрээгээр баригдаж байгаа 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц гүйцэтгэлтэй аймгийн Засаг даргын Тамгын газрын салбар хаируцсан мэргэжилтэн болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэнүүдийн хамтаар танилцаж хяналт хийв.

**Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:**

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/347 дугаар захирамжаар “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг батлуулж, албан бичгээр 7 хэлтэс, 17 сум, 65 албан байгууллагад хүргүүлэв.

Мөн 2017 оны эхний хагас жилийн байдлаар сумдаас ирүүлсэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

2017 оны 08 дугаар сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 32 тогтоол, 8 хуралдааны тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 80 тогтоол хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

**Долоо: Сумдын мэдээлэл:**

**Мөнххайрхан сум:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын Тамгын газар болон аймгийн хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгүүдээс ирүүлсэн чиглэлийн дагуу үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийг ард иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/93 тоот захирамжаар байгуулж, 2017 оны

08 дугаар сарын 07-ны өдөр Мөст суманд зохион байгуулагдсан сургагч багш нарыг бэлтгэх сургалтанд 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцлоо.

Хаг багийн ИНХ, Засаг даргатай хамтран 2017 оны 08 сарын 15-ны өдөр Хаг багт Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх, ард иргэдийн саналыг тусгай хуудсаар авах мөн сумын 90 жилийн ойн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, дээрх хэлэлцүүлэгт тус багийн 59 иргэн оролцсоноос 38 иргэнээс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудлаар санал авав.

Борт багт 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээнд тус багийн 63 иргэн оролцсоноос 42 иргэн саналаа өгсөн.

Алаг, Сэнхэр багуудын хэмжээнд айл өрхүүдийн байршил таруу байгаагаас шалтгаалан 2 ажлын хэсэг гарч, багийн нийт айл өрхөөр явж санал авах ажлыг 2017 оны 08 дугаар сарын 22-24-ны өдрүүдэд зохион байгуулж, 2 багийн нийт 70 гаруй өрхийн 124 иргэн санал өгсөнөөр сумын хэмжээнд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг, санал авах ажиллагаа 80%-тай үргэлжилж байна.

Сумын хэмжээнд бэлчээрийн ургац тогтоох судалгааг ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу холбогдох мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар 2017 оны 08 сарын 08-12-ны өдрүүдэд 4 багийн нутаг дэвсгэрт 16 цэгээс дээж авч судалгааны дүнг холбогдох байгууллагад хүргүүллээ.

Байгаль орчны тухай хууль, Амьтны тухай хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, 4 багт ажлын хэсэг гарган ажиллуулж, нийтдээ 100 гаруй өрхөд хүрч, гарын авлага, сурталчилгааны материал тарааж ажиллав.

Монгол Улсын байгаль Орчны яамны Бодлого судлалын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Ухаалаг малчин” хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 08 сарын 09-14-ийг хүртэл 5 хоногийн хугацаанд Байгаль орчны яамны Бодлого судлалын хүрээлэнгийн мэргэжилтнүүд, сумын ЗДТГ-тай хамтран малчдын 2 нөхөрлөлийн хүрээнд 2 дугаар шатны сургалтыг амжилттай зохион байгууллаа.

2017 оны 08 дугаар сарын 07-14-ний өдрүүдэд сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, аж ахуйн нэгж, иргэдээс 17 төслийг хүлээн авснаас 13 төслийг шалгаруулж, дээрх шалгарсан төслийн зээлдэгчтэй гэрээ байгуулж, нийт 37 сая төгрөгийн зээлийг олгов.

Дэлхийн хөхөөр хооллолтыг дэмжих өдрийг тохиолдуулан “Хөхөөр хооллолтыг дэмжих” аяныг 8 сарын 1-10-ны өдрүүдэд зохион байгуулж 0-5 настай хүүхэдтэй эцэг, эхчүүд болон жирэмсэн эхчүүдийг хамруулж, “Хөхөө хэрхэн арчлах, хөх зангиралтыг гаргах, хөхний сүүний ач холбогдол”-ын талаар сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгч нийт 54 хүн хамрагдав.

Сумын эрүүл мэндийн төв 11 дуудлага хүлээн авч, эмийн бус эмчилгээгээр нийт-27 хүнд үйлчилж, 22 хүүхэд дархлаажуулалтад хамрууллаа.

**Жаргалант сум:** Монгол улсын Засгийн газрын 2015 оны 122, 2016 оны 44, 45 дугаар тогтоолын дагуу үндэсний үйлдвэрт хонь тэмээний ноос тушаасан 45 малчин мал бүхий өрхийн 45 баримтыг хүлээн авч NOOS программд шивж мал хамгаалах санд хүргүүлээ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэх төслөөс зохион байгуулсан хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалтанд тус сумын 18 тариаланчийг хамруулж гарын авлага материалаар хангаж ажиллав.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан зарим заалтуудыг хэргэжүүлэх зорилгоор Жаргалант сумын ЗДТГ болон Баатархайрхан, Бугат, Буянт, Жаргалан, Рашаант ӨЭМТ-үүдтэй хамтарч 07 дугаар сарын 27-ноос 08 дугаар сарын 09-ний хооронд “Зуны сувилал”-ын төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Энэхүү төсөл хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумын 12 багийн 0-5 насны суурь өвчлөлтэй, археттай, цус багадалттай, сульдаатай 100 гаруй хүүхдийг үзлэг оношлогоонд хамруулж, тохирсон уламжлалт эмчилгээг үнэ төлбөргүй хийж, эцэг эхчүүдэд чийрэгжүүлэлт, зөв хооллолт эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох, дадал эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, цаашид зуны сувилалын үйлчилгээний чанар үр дүнг сайжруулж тогтмолжуулах, зөв орчинг бүрдүүлэх хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, эцэг эхчүүдийн оролцоог дээшлүүлэхэд хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2017 оны календарьчилсан төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Олон улсын аавуудын өдөр”-өөр 12 багийн аавуудын төлөөлөл болох 60 гаруй эрэгтэйчүүдэд хавдраас урьдчилан сэргийлэх, цаашид хэрхэн анхаарах, зөв хооллохын ач тусын талаар мэдээлэл өгч тэдний эрүүл мэндийн боловсролд мэдлэг олгов.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэх төслөөс зохион байгуулсан хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалтанд сумын 18 тариаланчийг хамруулж гарын авлага материал тараав.

Хан орд хүнсний захад хүнсний ногоо худалдан борлуулж буй 56 иргэний төмс, хүнсний ногооноос дээж авч аймгийн МХГ-ын лабораторид шинжилгээнд хамруулав.

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийтийг хамарсан ажлыг санхүүжүүлэх төслийн хүрээнд 10 иргэнийг ажиллуулж, Буянт голын сав дагуух зуслангийн айл өрхүүдээс хог хаягдлын үйлчилгээний хураамж 1 750 000 төгрөгийг сумын хот хөгжлийн төлөө сангийн дансанд төвлөрүүллээ.

Аймгийн Залуучууд хөгжлийн төвөөс санаачлан 2017 оны 08 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд “Залуучууд ба тогтвортой хөгжил” чуулганд 12 багийн 16-35 насны 40 гаруй оюутан залуусын төлөөллийг оролцуулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Залуучуудын зөвлөлд 12 багийн 23 иргэн Залуучуудын зөвлөлийн төлөөлөгчөөр, 9-н иргэн Тэргүүлэгчээр сонгогдлоо.

**Алтай сүм:** Сумын хэмжээнд Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 05, сумын Засаг даргын 04 тоот албан даалгавруудыг хүргүүлж баг, төсөвт байгууллагуудад хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл өгч, тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Сумын хэмжээнд 2000 тн, албан байгууллагууд тус бүр 4 тн хадлан тэжээл бэлтгээд байна.

Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх санал асуулгыг явуулах үйл ажиллагааг сум, багийн хэмжээнд зохион байгуулж, баг тус бүрээс оролцсон 213 иргэдийн саналыг нэгтгэн дүн мэдээг аймгийн ажлын албанд хүргүүлэв.

Аймгийн хэмжээний нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан Бодонч багийн нутаг “Улаан богч”, Алтангадас багийн нутаг “Майхан уул”-ын нөхөн сэргээлтийн нээлттэй сонгон шалгаруулалт зарлан хуулийн хүрээнд явагдаж, Улаан богчын нөхөн сэргээлтийг “Блю-Гоулд” ХХК, Майхан уулын нөхөн сэргээлтийг “Хавтаг богд” ХХК-ийр тус тус гүйцэтгүүлэхээр гэрээ байгууллаа.

**Ховд сүм:** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж зарим иргэдийг сумын хүндэт тэмдэгээр шагнах, хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох, Монгол

Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын түүхт 70 жилийн ойн баяр наадмыг 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд тэмдэглэх ажлын хүрээнд наадмын төв талбайн их засвар хийж угталын хаалга, хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн, дурсгалын хөшөө зэргийг ашиглатанд хүлээж авлаа. “Хөдөлмөр хөгжил 70 жил” ном бүтээлгэж сумын сүлд дуутай болохын зэрэгцээ урлаг, соёлын уралдаан тэмцээнүүдийг зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнүүдийг аймгийн ОНХ-ийн сангаас бүтээн байгуулалтанд зориулан олгосон 10 сая төгрөг, иргэн АА-ын нэгжийн сэлгэлийн хандиваар бүтээн босгож зохион байгууллаа.

Түүхт ойн баярын хурдан морины ажлын хэсгээс унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах, ослын даатгалд даатгуулах, хамгаалалтын хувцастай болгох чиглэлд түлхүү анхаарч аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, сумын Уяачдын холбоотой нягт хамтран ажилласны үр дүнд унаач хүүхдийн эрх зөрчигдсэн ямар нэг зөрчил гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн зүүн бүсийн сумдын хэлэлцүүлэг сургалтанд хамрагдаж сургалтаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус хэлэлцүүлэгийг сум, багийн хэмжээнд амжилттай зохион байгуулж саналыг нэгтгэн ажлын албанд хүргүүлэв.

“Малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хяналт тавих тухай” аймгийн Засаг даргын 2017 оны А/88 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган малын шилжилт хөдөлгөөн, урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, угаалга, туулгалт боловсруулалтын байдалд МЭҮТасаг тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төв алсын болон ойрын дуудлаганд цаг алдалгүй явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн ба 17 өвчтөн хэвтэн эмчлүүлэв.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 199 иргэнийг шинжилгээнд хамруулж, товлолын вакцинжуулалтанд 17 хүүхэд хамрагдав.

Сумын Засаг даргын Тамгын газар 3 өргөдөл хүлээн авч, 1 иргэний өргөдлийг сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлсэн ба 1 иргэний өргөдлийн хариуг амаар мэдэгдэж, 1 иргэний өргөдөл шийдвэрлэх шатандаа хүлээгдэж байна.

**Дөргөн сум:** Сумын ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаар 2017 оны хагас жилийн төсвийн тодотголыг хэлэлцүүлэн хурлын тогтоол шийдвэрийг аймгийн

Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн ба 2018 оны орон нутгийн төсвийг төсвийн төлөвлөлтийн мэдээллийн системд шивж байршуулав.

Монгол улсын үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, Өгөөмөр багийн иргэдийг оролцуулж тэдний саналыг нэгтгэн ажлын албанд хүргүүлэв.

Сумын бэлчээрийн ургацыг тодорхойлох зорилгоор Аргалант, Сээр багийн нутгаар фотомониторонгийн судалгаа хийж, дүн мэдээг аймгийн ГХБХБГ, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус хүргүүлэв.

Сумын хэмжээнд 1200 тн хадлан тэжээл, 200 тн гар тэжээл, 290 тн хужир шүү тус тус бэлтгэхээс 600 тн хадлан, 145 тн гар тэжээл, 143 тн хужир шүү бэлтгэгдээд байна.

2017 оны 08 сард 348 тэтгэвэр авагчдад 90632.9 мянган төгрөгийн санхүүжилтээр өндөр насны тэтгэвэр авагч 245, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 35, тахир дутуугийн тэтгэвэр авагч 68 иргэний тэтгэвэр тэтгэмжийг бүрэн олгож шинээр 4 иргэнд өндөр настны болон тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоов.

Сайн дурын даатгалд нийт 29 даатгуулагчийн 1018,000 төгрөгийн, Төсвийн байгууллага болон ААН-үүдээс нийт 19515,000 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, Эрүүл мэндийн даатгалд 34 хүний 1609,000 төгрөгийн орлого орууллаа.

Тэтгэмжийн даатгалын сангаас 5 эхэд 5560,0 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, өндөр насны тэтгэвэр авагч 1 иргэний оршуулгын тэтгэмжид 1000,000 төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдагч 1 иргэнд 60000 төгрөгийн тэтгэмж тус тус олгов.

Хууль бусаар алт олборлож байгаа Аргалант багийн Хөх эргийн аараг хэмээх газар хяналт шалгалт хийхээр ажлын хэсэг байгуулагдан 08 дугаар сарын 16-ны өдөр хяналт шалгалт хийж, алт олборлогч иргэдтэй уулзаж, дахин алт олборлохгүй байх талаар зохих арга хэмжээ авч ажиллаа. Тус газар нөхөн сэргээлт хийхээр сонгон шалгаруулалт зарлаад байна.

Сумын Эрүүл мэндийн төв 204 иргэнд үзлэг оношлогоо хийж, 15 алсын дуудлаганд явж, 12 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн ба эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 0-2 настай 22 эхэд эхийн сүүгээр

хооллохын ач тусыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах сургалт зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч гарын авлага тарааж тэдний санал бодлыг сонсов.

Сургуулийн үйлчилгээний ажилчид хамт олны сэтгэл зүтгэлээр сургуулийн дотуур байранд 1,8 сая төгрөгийн засвар хийж 2017-2018 оны хичээлийн жилд дотуур байранд амьдрах хүүхдүүдийг хүлээн авахад бэлэн болоод байна.

2017-2018 оны хичээлийн жилийн хүрээнд зохиогдсон багш нарын бага хуралд сургуулийн удирдлага, багш нар оролцож, шинэ хичээлийн жилийн зорилго, зорилтоо тодорхойлон нээлтийн арга хэмжээний бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн сурах хүсэл тэмүүлэл төрүүлэх, тэдний цэцэрлэгтээ явах дур сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн гадна, дотно талбайг тохижуулж чимэглэн тодорхой бодит ажлуудыг дотоод нөөц боломжоороо хийж гүйцэтгэв. Мөн тойргийн хүүхдийн судалгаа гаргаж бүлгийн багш тус бүр насны ангилалаар бүртгэл хийгдэж байна.

**Манхан сум:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийн талаар сум, багийн иргэдийн дунд олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж гарсан санал дүгнэлтийг нэгтгэн боловсруулж аймгийн ажлын албанд хүргүүлэв. Тус арга хэмжээнд 450 гаруй иргэд хамрагдсан ба энэ үеэр сумын удирдлагууд цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийж, хадлан тэжээл бэлтгэх, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд аймаг, сумын Засаг даргын албан даалгаварыг танилцуулж хийгдэх ажлын чиглэл өгч тэдний санал бодлыг сонсов.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард 527 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба урьдчилан сэргийлэх үзлэгт 121 хүн хамрагдаж 38 иргэн хэвтэн эмчлүүлж, товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 22 хүүхэд хамруулж 2 эхийг эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 18 дуудлаганд үйлчиллээ.

0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилт эрүүл мэндэд байнгын хяналт тавин ажиллаж хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж 90 хувийг тендэрээс авч хэрэглэв.

Сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг удирдамжийн дагуу Ботгон, Улаанхүрээ багийн нутаг дэвсгэрт хууль бус агнуурын болон “Манхан Баруун Баян Уул” отогийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж тодорхой үүрэг чиглэл өгч ажиллав.

Аймгийн Засаг даргын албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын захирамжаар хадлан тэжээл бэлтгэж сум, багийн нөөц бүрдүүлэх “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг”-ийг байгуулж, мал аж ахуйн болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах тухай сумын Засаг даргын албан даалгавар, ажлын төлөвлөгөөг гарган холбогдох баг, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүллээ.

**Мөст сум:** Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийн талаар иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах сумын хэмжээний бүсийн сургалтыг 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдөр ажлын хэсгийн гишүүд амжилттай зохион байгуулав. Сургалтанд Булган, Алтай, Үенч, Мөнххайрхан, Цэцэг, Мөст сумдын холбогдох албан тушаалтнууд болон иргэдийн төлөөлөл оролцлоо. Тус арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулж, уулзалт хэлэлцүүлэг, санал асуулгыг амжилттай зохион байгууллаа.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төслийн хүрээнд хийгдэх босоо тэнхлэгийн замтай Мөст сумыг холбох 20,5 км замын нээлтийн арга хэмжээ 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж тус арга хэмжээнд аймаг, сум болон гүйцэтгэгч компаний удирдлагууд оролцлоо.

Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж нийлүүлэх аж ахуй нэгжийг шалгаруулах тендэрийн сонгон шалгаруулалтыг 2017 оны 08 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулахаар зар мэдээг орон нутгийн телевизүүдэд өгч дэлгэрэнгүй мэдээллийг сумын албан есны веб сайтад байршуулаад байна.

Нийгмийн халамжийн сангаас 4 иргэн сар бүр 140000 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмжид 12 хүүхэд, ахмад настны асаргаанд 57 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаанд 18 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаанд 11 хүүхэд, бүтэн өнчин буюу асрамжинд байгаа 3 хүүхэд, 16-аас дээш насны эм тарианы үнэ ХБИргэн 10 хүн, ахмад настан 18 хүн, 16-аас доош насны эм тарианы үнэ 11 хүүхдэд сар бүр 140000 мянган төгрөгийг тус тус олгов.

Эмч нарын магадлах комиссын шийдвэрийг үндэслэн амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн 2 иргэнд 130000 төгрөгийн хөнгөлөлт 2 ахмад настанд шүдний хөнгөлөлт 240000 мянган төгрөгийг тус тус олгов.

Сумын хэмжээгээр 18 өрхийн 104 гаруй хүүхэд болон насанд хүрсэн иргэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж байна.

Сумын 12 цэгийн бэлчээрийн даацад фотомониторинг хийсэн ба царцаа устгалын ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлэв.

Сумын эрүүл мэндийн төв нь урьдчилан сэргийлэх үзлэгийг 352 иргэнд хийж, гэрийн идэвхитэй хяналтаар 110 иргэнийг авч 29 иргэнд дуудлагаар үйлчилж, 4 эхийг жирэмсний хяналтанд авч эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сумын иргэдэд шуурхай хүргэж ажиллав.

**Чандмань сум:** Сумын Засаг даргын Тамгын газар нь аппаратын өргөтгөсөн шуурхай зөвлөгөөн зохион байгуулж орон нутагт хийгдэх цаг үеийн болон өвөлжилтийн бэлтгэл ажил хангах талаар хэлэлцэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг сумын хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага малчдын төлөөллийг оролцуулан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулснаар 400 иргэний саналыг авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүллээ.

Төлөвлөгөөний дагуу “Төрийн үйлчилгээ Таны багт” нээлттэй хаалганы өдөр арга хэмжээг Тахилт багийн төвд зохион байгуулж тус арга хэмжээнд сумын удирдлагууд болон төсөвт байгууллагуудын төлөөлөл оролцож иргэний бүртгэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, татвар төлөлт, газрын гэрчилгээ олгох, хуулийн зөвлөгөө өгөх сангуудын талаарх мэдээлэл өгч төрийн үйлчилгээг иргэдэд хүргэв.

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хэсэг байгуулагдан 14 заалт бүхий төлөвлөгөө гарган өвөлжилтийн бүс тогтоож, хадлан тэжээл бэлтгэх, ажлыг зохион байгуулан гүйцэтгэл 20%-тай байна.

Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 6, нас баралт 2, шилжин явсан 5, шилжин ирсэн 1, 25, 45 насны иргэдийн паспортын сунгалт 15 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

“Дэлхийн байгаль хамгаалах сан”, “Ногоон алт” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр сумын мал эмнэлэг үржлийн тасаг, бэлчээр ашиглагчдын холбоо хамтран “Малын эрүүл мэндийг хамгаалах нь”, “Бэлчээр ашиглагчдын өнөөгийн төрх

цаашид ажиллах зарчим” зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, тус үйл ажиллагааны үеэр малын эрүүл мэндийг хамгаалахад иргэд, МЭҮТ, МЭҮНэгжүүдийн оролцоо, анхаарах асуудлын талаар санал асуулга авч цаашид анхаарч ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулан 126 иргэдийг хамруулсан үр дүнтэй томоохон арга хэмжээ болов.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд Амьжиргааг дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж, нийт 704 иргэнд 171914.0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 66 иргэнд 25344.0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 118 иргэнд 27100.0 мянган төгрөг, ахмад настаны унааны зардалд 18 иргэнд 2730.0 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал 3 иргэнд 160.0 төгрөгийн тэтгэмж тус тус олгов.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 9627.3 мянган төгрөг, Иргэний сайн дурын даатгалд 34 иргэнээс 2595.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 21 иргэнээс 861.1 мянган төгрөг нийт 13083.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүллээ.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 80436.0 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 258 хүнд 69769.9 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмжийг 12 хүнд 2767.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж 33 хүнд 2767.0 мянган төгрөгийг тус тус олгов.

Сумын Эрүүл мэндийн төв нь 112 иргэнд амбулаторийн үзлэг хийж 29 иргэнийг хэвтүүлэн эмчилж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэж үйлчлэв.

Боловсролын байгууллагын ажилчдын ээлжийн амралтын хугацаа дуусаж, 12 жилийн бүрэн дунд сургууль болон цэцэрлэгийн багш нар аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулсан бага хуралд төлөөлөл болох 15 хүн оролцсон ба хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил мөн гадна тохижолтын ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

**Цэцэг сүм:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 05 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор сумын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, хадлан тэжээл бэлтгэх сумын Засаг даргын захирамжаар өвөлжилтийн бэлтгэл

хангах ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг гарган холбогдох баг, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.

Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх, сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг Цэцэг нуур, Хажинга, Баянгол, Баяновоо, Хөшөөт багийн ард иргэдийн саналыг тусгай хуудсаар авч 400 гаруй иргэний саналыг нэгтгэн аймгийн ажлын албанд хүргүүлэв.

Мо-Эн-Ко ХХК-ны нүүрс тээвэрлэлт нь байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл байдал, ган гачиг тоосжилт, хуурайшилт, дуу чимээ, усны бохирдолт, орчны сөрөг нөлөөлөл их байгааг харгалзан сумын Засаг даргын захирамжаар үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргаж гэрээнд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

1. Хөшөөт багийн тосгоныг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах
2. Хөшөөтөөс Цэцэг нуур баг хүртэлх 4,9 км замыг Мо-Эн-Ко ХХК, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран хийж гүйцэтгэх
3. Аж ахуй нэгж, албан байгууллага, ард иргэдэд Мо-Эн-Ко ХХКомпани нь 1 тонн нүүрсийг 40 мянган төгрөгөөр өгдөг байсныг 25 мянган төгрөгөөр олгох зэрэг болно.

**Үенч сүм:** Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор хадлангийн бүс нутгуудад бүх нийтээр 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хадлан тэжээл бэлтгэж сумын хэмжээнд 3500 тн хадлан бэлтгэгдээд байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг сумын хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын А/79 дугаар захирамжаар байгуулж, сум болон хөдөөгийн 5 багийн иргэдийг бүрэн хамруулж, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүллээ.

Сумын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, хадлан тэжээл бэлтгэж сум, багийн нөөц бүрдүүлэх ажлын хэсэг байгуулагдан төлөвлөгөө зураглал гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Цагаан түнгэ, Нарийн гол, Жаргалан багийн бэлчээр ашиглалтын хэсгийн 12 цэгээс фотомониторингийн аргаар бэлчээрийн даац тодорхойлох зураглал боловсруулж аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлчээр хариуцсан мэргэжилтэнд тус тус хүргүүлэв.

Бог малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хийгдэж байна.

**Буянт сум:** Сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант сард иргэдээс 6 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэв. Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээ авах 181 иргэнийг хүлээн авч үүнээс шинэ төрсөн хүүхэд 48 /эрэгтэй 29, эмэгтэй 19/, гэрлэлтийн 20 бүртгэл, нас баралт 15, /эрэгтэй 11, эмэгтэй 4/, иргэний шинэчилсэн бүртгэл 84 мөн 37 иргэнд шинээр үнэмлэх олгож 25 насны сунгалт 22, 45 насны сунгалт 25, эцэг тогтоолтын бүртгэл 7, эд хөрөнгийн бүртгэлийг 39 иргэнд тус тус үзүүлж үйлчиллээ.

Орон нутгийн төсөвт 4.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2.7 сая төгрөг буюу 64.2 хувийн гүйцэтгэлтэй байна. 08 дугаар сарын 24-ны байдлаар улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 26092776 төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагууд төлөвлөгөөний дагуу өөрийн байгууллагын санхүүжилтийг 100% авч тайлант хугацаанд сум хөгжүүлэх сангийн дансанд үндсэн зээл, хүүгийн төлбөрт 3.3 сая төгрөг төвлөрүүлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зарлага санхүүжилтийн 8 дугаар сарын мэдээг ЗДТГ-ын ил тод байдлын мэдээллийн самбар, сумын вэб сайтад байршуулж, 5 төрлийн мэдээ тайланг маягтын дагуу хугацаанд нь нэгтгэн гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэв.

Сумын Соёлын төв төлөвлөгөөний дагуу арга хэмжээ зохион байгуулагдаж, 130 гаруй иргэнд соёлын үйлчилгээ үзүүлж, 200.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс 185 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 8 төрлийн номоор 23 иргэнд хүрч үйлчиллээ.

Сумын Эрүүл мэндийн төв нь 08 дугаар сард 128 иргэнд үзлэг хийв. Үүнээс амбулаторын үзлэг 105, урьдчилан сэргийлэх үзлэг 17, гэрийн идэвхитэй эргэлт 6 удаа хийж нийт 27 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн ба алсын дуудлага 17, ойрын дуудлагад 8 удаа явж эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламжийг цаг алдалгүй хүргэлээ. Тус сард товлолын дагуу хөдөөгийн багуудаар явж дархлаажуулалтанд 23 хүүхэд хамруулж, 0-3 сартай жирэмсэн эхийг бүрэн хяналтанд авч, зохих шинжилгээнд хамруулав.

Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлтөнд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч цаг хугацаанд нь программд шивж

оруулан, ахмад настны нэг удаагийн тэтгэмж тусламж болох шүд хийлгэсний үнийн хөнгөлөлтийг 4 иргэнд 400,0 төгрөг, ХБИ-нд хийлгэсэн шүдний үнэ 1 иргэнд 120,0 мянган төгрөг тус тус олгов. Хөдөлмөрийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг нийтэд сурталчлан ажиллаж байгаа ба ажилгүй иргэдийн судалгаа шинэ ажлын байрны сарын мэдээг сар бүр тогтмол гаргаж, 8 өрх хүнс тэжээл хөтөлбөрт хамрагдан хүнсний дэмжлэг авч байгаа ба сардаа 552000 төгрөгийн санхүүжилт хийгдэж байна.

“Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт” төслийн хэлэлцүүлгийг сум багийн хэмжээнд зохион байгуулж хэлэлцүүлэгт 83 иргэн хамрагдаж санал бодлоо солилцон саналыг нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлэв.

**Зэрэг сүм:** Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах хугацаа тогтоох, үүнд малчдыг татан оролцуулах тэдний санал бодлыг сонсох зорилгоор багийн Иргэдийн Нийтийн хурлуудыг зохион байгуулж мал аж ахуйн 4 багийн 240 орчим иргэд, сумын удирдлагуудын хамтаар оролцож санал бодлоо солилцов.

Бидний цөөхөн Монголчууд төслийн баг 8 дугаар сарын 07-14-ий өдрүүдэд ажиллаж, малчдын нүүдлээр баримтат кино хийх зураг авалтыг сумын Засаг даргын Тамгын газар төслийн багийнхантай хамтран зохион байгууллаа.

Монгол улсын Зэвсэгт хүчний жанжин штабаас бригадын генералаар ахлуулсан ажлын хэсэг сумын удирдлагуудтай уулзаж, Локаторын цэргийн ангийг суманд байгуулахаар харилцан ярилцаж, санал бодлоо солилцон сум орны нөхцөл байдалтай танилцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг сумын хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулж, бүсчилсэн сургалтанд сум болон багуудаас оролцох 168 иргэдийг бүрэн хамруулж, иргэдийн саналыг авч нэгтгэн холбогдох ажлын албанд хүргүүллээ.

Засгийн газрын 186 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 01, аймгийн Засаг даргын 05, 07 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулж, 3 бүлэг 27 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган ард иргэд, албан байгууллага, малчдад зөвлөгөө өгч холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Онцгой байдлын газартай хамтран суманд гал унтраах, аврах анги байгуулахад шаардагдах ажиллах хүчний судалгааг гаргаж хүргүүлсэн ба шалгаруулж авах ажил хүлээгдэж байна.

Барилга хот байгуулалтын яамны харъяа Барилгын хөгжлийн төвийн ажлын хэсгийн баг 8 дугаар сарын 23-ний өдөр сумын нэгдсэн дулаан хангамжийн ажлын явц, гүйцэтгэлтэй танилцан хяналт хийж, тодорхой үүрэг чиглэл өгөв.

Сумын 12 жилийн бүрэн дунд сургууль болон Хүүхдийн цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн сургалт, хүмүүжлийн ажлын бэлтгэл, байгууллагын урсгал засвар, тохижилтын ажил бүрэн хийгдсэн төдийгүй сургууль завсардсан, бүрэн дунд боловсрол эзэмшээгүй насанд хүрэгчдийн судалгааг гарган насан туршийн боловсрол төвд хүргүүлэв.

**Эрдэнэбүрэн сүм:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг сумын хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулж, бүсчилсэн сургалтыг суманд зохион байгууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/65 тоот захирамжаар байгуулан байгалийн хадлан тэжээл бэлтгэх ажлыг эхлүүлж, хадлан 3300 тн, гар тэжээл 270 тн, хужир шүү 615 тн бэлтгэхээр төлөвлөж, 08 дугаар сарын 25-ны байдлаар хадлан бэлтгэл 90 хувьтай байна.

Сумын бэлчээрийн ургацын фотомониторингийн судалгааны ажлыг Швейцарын хөгжлийн агентлаг Бэлчээрийн менежментийн холбоотой хамтран зохион байгуулав. Монгол мал хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй төл малыг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/73 тоот захирамжаар байгуулж, сумын хэмжээнд нийт 57800 төл хамрагдахаас вакцинжуулалт 5 хувьтай байна.

Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 555 иргэн хамрагдахаас тайлант сард 338 иргэн хамрагдаж, хамрагдалт 75 хувьтай байна. С вирус илэрсэн 49 иргэний шинжилгээг авч дараагийн шатлалын эмнэлэгт ачаалал тоолох шинжилгээнд хүргүүлэв.

**Булган сүм:** Аймгийн Засаг даргын орлогч Ш.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг сумын удирдлагуудтай уулзаж өвөлжилтийн бэлтгэл ажил хэрхэн хангах, хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэх талаар чиглэл өгч аймгийн Засаг даргын албан даалгаварыг танилцуулсан ба шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэг, хүн

эмнэлэгийн барилгын ажлын явц гүйцэтгэлтэй танилцан ажлыг эрчимжүүлж, хугацаанд нь хийж гүйцэтгэж дуусгах үүрэг даалгавар өгөв.

Сумын өнгө үзэмжийг сайжруулах, цэвэр орчин бүрдүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлгийн хамт олон Булган голын сав дагуух хогийг цэвэрлэх аян зохион байгуулж тус арга хэмжээнд Засаг даргын Тамгын газар, Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны алба хаагчид болон төсөвт байгууллагуудын ажилчид идэвхитэй оролцож 2 машин хурсан хогийг ачиж хогийн цэгт устгав. Мөн ажилчдын нөөц, хүн хүчний боломжид тулгуурлан ашиглалтын хугацаа дууссан хийн баллоны саваар 10 ширхэг хогын сав хийж сумын төв гудамж дагуу шинээр байршууллаа.

Сумын хэмжээнд ургац хураалт, хадлан тэжээлийн бэлтгэл ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын захирамжаар томилж гишүүд тус арга хэмжээг сум, багийн хэмжээнд амжилттай гүйцэтгэж хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн саналыг нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлэв.

**Мянгад сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 оны 08 дугаар сард Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж сумын Засаг даргаас өргөн мэдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх газрын байршил тогтоох, Чацарганат багийн Улиастайн рашааныг ашиглах журам батлах тухай багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, Шим-Ус ХХК-ны Мянгад дахь салбар орон нутгийн мэдэлд шилжсэнтэй холбогдуулан ОНӨААТҮГ газар байгуулан, түүний үйл ажиллагааны дүрмийг батлах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг сумын хэмжээнд хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулж, тэдгээрийг Эрдэнэбүрэн суманд болсон бүсчилсэн сургалтанд сум болон багуудын иргэдийг бүрэн хамруулж, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулснаар 400 иргэний саналыг авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүллээ.

Монгол Улсад Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 25 жилийн ойн арга хэмжээний хүрээнд суманд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Засаг даргын Тамгын газар нь тайлант сард дээд байгууллагуудаас нийт 22 албан бичиг хүлээн авснаас хугацаатай 8 бичиг хүлээн авч 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 6 албан бичгийн хугацаа болоогүй хүлээгдэж байгаа ба нийт 10 албан бичгийг холбогдох байгууллагуудад явуулсан байна.

Иргэдээс ирүүлсэн ажилд орохыг хүссэн, шинээр их, дээд сургуульд элсэн суралцахаар болсон оюутны сургалтын төлбөрийн зээл, хөнгөлөлтийн чиглэлээр холбогдох сургуулиудад нь хүсэлт уламжлуулах тухай зэрэг 12, Улсын бүртгэлийн чиглэлээр 64, Нийгмийн даатгалын чиглэлээр 6 нийт 82 өргөдөл хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэлээ.

Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулж, сумын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, хадлан тэжээл бэлтгэж сум, багийн нөөц бүрдүүлэх асуудлыг хэлэлцэж, сумын Засаг даргын захирамжаар “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг”-ийг байгуулж, мал аж ахуйн болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах тухай сумын Засаг даргын 01, 02 дугаар албан даалгавар, ажлын төлөвлөгөөг гарган холбогдох баг, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүллээ.

Дээрх ажлын хүрээнд багийн Засаг дарга нар 2017 оны 08 дугаар сарын 01-08-ны өдрүүдэд нийт малчин, тариаланч өрхүүдээр орж Монгол улсын Засгийн газар, аймаг, сумын зүгээс хийгдэж байгаа ажлын талаар, өвөлжилтийн бэлтгэл хангаж өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хадлан хийж өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, отор нүүдэл хийх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч, тус сумын нутагт гаднаас ирж өвөлжих, сумаас гадагш гарч өвөлжих малчид, мал, худалдан борлуулах малын тоо судалгааг авч ажиллалаа.

Мөн тус сумын хадлангийн бүс нутаг болох Цагаанбулан багт хадлан хийж байгаа хадланчидтай гэрээ байгуулан ажиллаж, дээрх ажлуудын үр дүнд нийт 6000 тонн өвс бэлтгэхээр төлвөлсөнөөс 1800 тонн өвс бэлтгэгдэж, 10000 толгой мал худалдан борлуулах, 634 суурьт хонин толгойд шилжүүлснээр 380936 толгой мал өвөлжих урьдчилсан тоо гараад байна.

Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын хүрээнд Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хуулиудаар сум, баг, албан байгууллагуудын удирдах ажилтнууд, төрийн захиргааны ажилтан албан хаагчидад сургалт зохион байгууллаа.

Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 64 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Үүнд: Шинээр төрсөн хүүхэд 8, гэрлэлт 4, нас баралт 2, эцэг тогтоолт 2, шилжин явсан 8, шилжин ирсэн 11, үл хөдлөх хөрөнгийн эрхийн бүртгэлээр газар өмчлөх гэрчилгээ 1, иргэний цахим үнэмлэх 31, гадаад паспорт авахыг хүссэн 2 өргөдөл байгаа ба хуулийн хүрээнд бүртгэл, мэдээллийн үйлчилгээг бүрэн хүргэлээ.

**Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагааны мэдээлэл:** Сумын Хүүхдийн цэцэрлэг хичээлийн шинэ жилийн сургалт, хүмүүжлийн ажлын бэлтгэл ажлыг ханган байгууллагын урсгал засвар, тохижилтын ажлыг хийсний дээр “Номын гэгээ”, “Чадварлаг багш”, “Бидний өв соёл” ажлын хэсгүүдийн ахлагч нар 2017-2018 оны хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. Тус байгууллагын тогооч М.Цэвээнжав Баруун бүсийн тогооч нарын зөвлөгөөний үеэр зохион байгуулагдсан “Аварга тогооч, зөөгч” шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Хүрэл медаль хүртлээ.

Эрүүл мэндийн төв нь нийт 354 амбулаторийн үзлэг хийж 15 иргэнийг хэвтүүлэн эмчилж, нийт 8 алсын дуудлаганд явж үйлчилсэн байна. Мөн 0-3 сартай 5 жирэмсэн эхийг жирэмсний эрт хяналтанд авч, энэ сард хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 8 эмэгтэйг 100 хувь шинжилгээнд хамруулж ажиллалаа. Товлолын дархлаажуулалтыг 2-4 сартай нийт 7 хүүхдэд Тавт вакцин, 9 сартай 6 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцин, 1, 2 настай 11 хүүхдэд А гепатитын эсрэг вакцин, 2 настай 8 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцины 2 дахь тунг тус тус тарьж дархлаажуулалтыг товлолын дагуу бүрэн хийлээ.

Баянхошуу багийн Долоогийн газарт тариалан эрхэлж буй иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, 13 иргэнээс элэгний В, С вирус илрүүлэх, 7 хүнд серологийн шинжилгээ хийлээ. Хөхөөр хооллолтыг дэмжих өдрийг тохиолдуулан 10 жирэмсэн эхэд Хөхөөр хооллолтын ач холбогдол, нярайн асаргаа сувилгаа, эх хүүхдийн дэвтэр хөтлөлтийн талаар 13 эхэд сургалт явууллаа. “Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг 125 иргэнд зохион байгуулж 51 иргэнд Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг илрүүлэх шинжилгээ хийж үүнээс эерэг илэрсэн 9 иргэнийг дахин онош баталгаажуулахаар шинжилгээний сорьц тээвэрлэж оношийг баталгаажуулан эмчлэн эрүүлжүүлэхээр ажиллаж байна.

Мөн “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд нийт 80 иргэнд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээг хийснээс В вирус 5, С вирус 3 илэрч тухайн иргэдэд цаашид хийлгэх эмчилгээний зааварчилгааг өгч ажиллалаа. Эмнэлгийн тусгай хог хаягдалыг хаях зориулалтын 30м<sup>2</sup> талбай бүхий хогийн цэгийг эмнэлгийн өөрсдийн нөөцөд түшиглэн барилаа.

Ерөнхий боловсролын сургууль хичээлийн шинэ жилийн сургалт, хүмүүжлийн ажлын бэлтгэл хангах ажлын хүрээнд хичээлийн болон Дотуур байрны урсгал засварыг бүрэн хийж дуусгасаны дээр 2017-2018 оны хичээлийн жилд АНУ-ын Энхтайвны корпусын чиглэлээр гэрээгээр ажиллах багшийг хүлээн авч амьдрах гэрийг барьж тохижуулав.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 85 иргэнд 1190,0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж 46 иргэнд 1840,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж 13 иргэнд 832,0 мянган төгрөг, ахмад настан асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж 16 иргэнд 1024,0 мянган төгрөг, Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэсний унааны нэг талын зардалд 2 ахмад настанд 130,0 мянган төгрөг тус тус олгов. Нийгмийн даатгалын ажлын хүрээнд сайн дурын даатгалд 31 иргэнээс 1250,3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 25 иргэнээс 987,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэв. Тэтгэвэрийн даатгалын санд 101125,0 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр настны тэтгэвэрийг 351 хүнд 81063,0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг 31 хүнд 7776,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрийг 70 иргэнд 16748,0 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 1 иргэнд 305,3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 6 иргэний хүсэлтийг хүлээн авч шинээр тэтгэвэр тогтоов.

**Эдийн засаг, төсөв, санхүүгийн салбарын үйл ажиллагааны мэдээлэл:**  
Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 83,1 сая төгрөг орон нутгийн санхүүгийн дэмжлэг 19,3 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэнээс Засгийн газрын төлбөр тооцооны төрийн сангийн фрийбаланс программаар тусгай шилжүүлгээр санхүүждэг болон орон нутгийн төсөвт байгууллагуудын сар бүрийн санхүүжилтийг төвлөрүүлэн өдөр тутмын гүйлгээг анхан шатны баримттай тулган шивж 49,5 сая төгрөгийн 47 гүйлгээг хийж гүйцэтгэлээ.

Мөн Сум хөгжүүлэх сангаас 14 сая төгрөгийн зээлийг 4 иргэнд олгож, сум орон нутгийн болон төсөвт байгууллагуудын төлөвлөгөөний дагуу төсвийг байгууллагуудад

хуваарилан, зардлын зүйл анги тус бүрээр нь хяналт тавьж, төрийн сангийн төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийг санхүүгийн стандарт маягт, заавар журмын дагуу бодит тоон үзүүлэлтээр үнэн зөв гарган ажиллав.

**Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчин, газар зохион байгуулалт, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны мэдээлэл:** Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар тодорхойлох ажлыг 2017 оны 08 дугаар сарын 10-11-ны өдрүүдэд 5 багийн 12 цэг тус бүрт 19 зураг авч нийт 228 фото зургаар баталгаажуулан судалгааны зургуудыг аймгийн ГХБХБ-ын газарт хүргүүлэв. Мөн энэ онд газрын төлбөрт 3560.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2017 оны 08 дугаар сарын байдлаар 2215,2 мянган төгрөгийн орлогыг аймгийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна.

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын А/404 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах, сумын бэлчээрийн даац багттаамжийг тодорхойлох зорилгоор 5 багийн нутаг дэвсгэрт бэлчээр ажиглалтын 5 цэгт бэлчээрийн даац, багтаамж тодорхойлох ажлыг хийж 25 ширхэг дээж авч, хуурай нойтон жинг хэмжин, тухайн орчны ургамлыг тодорхойлж, ургамлын суурь хоорондын зайн хэмжилт хийж, тайлан мэдээг аймгийн Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүллээ. Тус сумын Баянбулаг, Цагаанбулан багуудын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулах эрх бүхий “Хос орчлон”, “ММНС” ХХК-иудын хайгуулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежмент төлөвлөөгөөг хянаж, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө нийт 550.0 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажиллаа.

Баянбулаг багийн нэр бүхий 2 малчны хотноос цусан халдвар өвчний сэжиг илэрсэн тул онош тодруулахаар дээж авч аймгийн Мал эмнэлэгийн лабораторид хүргүүллээ. Мөн Баянбулаг, Гахайт, Чацаргант багуудын хуц, ухнаас бруцеллөз өвчний шинжилгээ хийлгэхээр цусны шинжилгээ авч аймгийн Мал эмнэлэгийн лабораторид хүргүүлсэний дээр уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нийт төл малыг вакцинжуулах ажлыг суман дахь МЭҮН-үүд хийж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.АЛИМАА

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ГАНБОЛД